



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Г Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг Г  
бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мост финтек” ХХК-ийн нэг бүр нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 466,716,642 /дөрвөн зуун жаран зургаан сая долоон зуун арван зургаан мянга зургаан зуун дөчин хоёр/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Мост финтек” ХХК-ийн нэг бүр нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 311,300,000 /гурван зуун арван нэгэн сая гурван зуун мянга/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 51,883,350 /тавин нэгэн сая найман зуун наян гурван мянга гурван зуун тавь/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 47 /дөчин долоо/ төгрөгөөр “Мост Финтек” ХХК-ийн тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид худалдахыг зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 51,883,350 /тавин нэгэн сая найман зуун наян гурван мянга гурван зуун тавь/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 47 /дөчин долоо/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Мост Финтек” ХХК /А.Сүхдорж/-д зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын 3, 4-т заасан нийтэд санал болгон худалдаалах хувьцааг 100 /нэг зуун/ хувь зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасны анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “Мост Финтек” ХХК /А.Сүхдорж/-д мэдэгдсүгэй.

6. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын 2, 3-т заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

8. Энэ тогтоолын 5-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Эс Жи Капитал ҮЦК” ХХК /Э.Сод-Эрдэнэ/-д анхааруулсугай.

9. Энэ тогтоолын 3, 4-д заасан хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны эрэлт нь нийлүүлэлтээс давсан тохиолдолд энэ тогтоолын 1-д заасан 466,716,642 /дөрвөн зуун жаран зургаан сая долоон зуун арван зургаан мянга зургаан зуун дөчин хоёр/ хувьцаанаас нэмж 11.1 хувь буюу 51,649,942 /тавин нэгэн сая зургаан зуун дөчин есөн мянга есөн зуун дөчин хоёр/ ширхэг хүртэлх хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийг 47/дөчин долоо/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрч, худалдагдаагүй үлдсэн хэсгийг хүчингүйд тооцохыг “Мост Финтек” ХХК /А.Сүхдорж/-д мэдэгдэж, энэ тогтоолын 1-д заасан үнэт цаасны тоо хэмжээнд холбогдох өөрчлөлтийг оруулж бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

10. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлүүлэх зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын хугацаанд үнэт цаасны үнэ ханш хэт савлах, буурах, жижиг хөрөнгө оруулагчийн эрх ашиг зөрчигдөх эрсдэлээс сэргийлсэн арга хэмжээг авч, зах зээл үүсгэгчийн үүрэг гүйцэтгэхийг “Мост Финтек” ХХК /А.Сүхдорж/, “Эс Жи Капитал ҮЦК” ХХК /Э.Сод-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

11. “Мост Финтек” ХХК нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Мост Финтек” ХХК /А.Сүхдорж/-д үүрэг болгосугай.

12. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Эс Жи Капитал ҮЦК” ХХК /Э. Сод-Эрдэнэ/, “Өмгөөллийн Батбаяр энд партнерс” ХХН /Г.Батбаяр/, “Хүлэгт хүннү Аудит” ХХК /Ё.Наранбилэг/, “Координат Аудит” ХХК /П.Баярмаа/-д тус тус анхааруулсугай.

13. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 5 дугаар сарын 23-ны  
өдрийн 126 дугаар тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчийн нэрс	Регистрийн дугаар	Хувьцааны тоо ширхэг
1	А.Сүхдорж	ХП51022016	169,500,000
2	“ГрэйпСити Монгол” ХХК	2598574	126,200,000
3	“ИТ Компас” ХХК	5077605	15,200,000
	Нийт дүн		311,300,000